



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/1

Мандалговь

Г Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын Ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Газрын удирдлагын хэлтсийн дарга (Б.Рэнцэндорж)

Гишүүд: Захиргаа, хуулийнасуудал харууцсан ахлах мэргэжилтэн

(Д.Болорчимэг)

Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал
харууцсан ахлах мэргэжилтэн (Т.Саранзул)

2. Байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

3. Нийт албан хаагчдад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хөвшүүлэн, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг мөрдлөг болгон ажиллахыг Ёс зүйн зөвлөл (Б.Рэнцэндорж)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус байгууллагын даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/21 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Э.ЧАГНААДОРЖ

ГХБХБГ-ЫН 2023 ОНЫ 05 дугаар сарын 03-ны
өдрийн 05 дугаар тушаалтын хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн зорилго нь төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчдын мэргэжлийн ёс зүйг мөрдөж, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, аливаа зөрчил, гажуудлаас сэргийлэхэд оршино.
- 1.3. Байгууллагын Ёс зүйн зөвлөл нь нийт ажиллагсдын саналаар сонгогдсон, ажиллагсдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус байна.
- 1.4. Хорооны үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм тэдгээртэй нийцүүлэн гаргасан гаргасан хууль тогтоомжийн бусад актуудын хүрээнд явагдана.
- 1.5. Зөвлөл нь үйл ажиллагаанд хууль дээдлэх, тэгш байдал, шударга ёсыг баримтлах, нууцыг нууцыг хадгалах, хараат бус байх зарчмуудыг баримтална.

Хоёр. Байгууллагын ёс зүйн хорооны эрх, үүрэг

- 2.1. Төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах
- 2.2. Гомдол, мэдээлэлд холбогдох төрийн захиргааны албан хаагч болон түүний харьяалах төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гомдол мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо материал, баримт бичгийг шаардан авах
- 2.3. Гомдол мэдээллийн нууцлалыг хадгалах, шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахуулахаар холбогдох байгууллагад хандах
- 2.4. Гомдол, мэдээллийг хуралдаанаасаа хэлэлцэж шалгасан тухай дүнг гишүүдийн олонх саналаар дүгнэлт өгөх
- 2.5. Хороо нь гомдол, мэдээллээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мэрөөр, түүнчлэн өөрийн санаачлагаараа болон байгууллагын нэгжийн дарга, газрын дарга нараас ирүүлсэн санал гомдлыг хүлээн авч зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах

2.6. Байгууллагын Ёс зүйн зөвлөл нь төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлнэ. Жилийн эцсийн тайланг өгсөн дунгээр гарган салбар зөвлөлийн жилийн ажлын тайлангийн хамт файлаар болон цаасаар Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлнэ.

Гурав. Байгууллагын Ёс зүйн хорооны дүгнэлт

- 3.1. Байгууллагын Ёс зүйн зөвлөл дүгнэлтээ эрх бүхий албан тушаалтан /байгууллагын дарга/-д танилцуулна.
- 3.2. Энэхүү журмын 2.2-т заасан эрх бүхий байгууллага албан тушаалтан нь Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг хянаж үзээд дараах үндэслэлээр дахин шалгуулахаар Ёс зүйн зөвлөлд буцаах шийдвэр гаргаж болно. Үүнд:
 - Ёс зүйн зөрчил гаргасан нотолгоо, баримт бичгийн бүрдэл хангагдаагүй
 - Холбогдох нотолгоо, баримт бичиг, материалыг шалгаагүй буюу хангалтгүй шалгасан
- 3.3. Байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан /дарга/ нь Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийн дагуу тухайн төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх шаардлагагүй гэж үзвэл энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргаж, холбогдох талуудад мэдэгднэ.
- 3.4. Төрийн захиргааны албан хаагч ёс зүйн зөрчил гаргасныг тогтоож, сахилгын шийтгэл ногдуулахаар гаргасан байгууллагын Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт, байгууллагын удирдлагын саналыг Төрийн албаны салбар зөвлөлд холбогдох баримт, материалын хамт хүргүүлнэ.